## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН /ХБТХОХ/

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ** | | | | | | | |
| **Зорилт-1: Эдийн засгийн хөгжлийн төлөв байдал, хандлага, чиглэлийг боловсруулах** | | | | | | | |
| 1.1 | Аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд гол үүрэгтэй тэргүүлэх салбаруудыг тодорхойлж, дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийг боловсруулан, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах. | - | Хэрэгжилтийн хувь<br><br>Тайлагнах хугацаа | 96.2 хувь<br>Хуулийн хугацаанд тайлагнасан | 98-аас дээш хувьтай гүйцэтгэсэн байна.<br>Хуулийн хугацаанд тайлагнасан | Орхон аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2025 оны эхний хагас жилийн байдлаар 95.5 хувьтай хэрэгжиж байна. Орхон аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах ажлын хэсгийг Засаг даргын 2025.03.13-ны А/202 дугаар захирамжаар баталсан. Боловсруулалпрт хийх дэд ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, ажлын хэсгийн гишүүдэд Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бодлогын баримт бичиг боловсруулах аргачлалын талаар мэдээлэл өгсөн. Ажлын хэсэг салбар бүрт тулгамдаж буй асуудлаа тодорхойлон, нөхцөл байдлын дүн шинжилгээ хийн, үндсэн чиглэлийн төслийг үр дүнд суурилсан аргачлалаар боловсруулж байна. | 100% |
| 1.2 | "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ын зорилтыг аймгийн бодлогын баримт бичигт тусган хэрэгжилтийг зохион байгуулах | - | Тусгасан бодлогын баримт бичгийн тоо | 1 | 2 | "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-д тусгагдсан Зэс боловсруулах, металлурги- химийн үйлдвэр болон бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэр технологийн парк байгуулах, ."Сургалт-Эрдэм шинжилгээ- Үйлдвэрлэлийн цогцолбор" хотхоныг байгуулах, Бүсийн тээвэр логистикийн төвийг байгуулах, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Аялал жуулчлалыг бүс орон нутгийн онцлогт түшиглэн төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөгжүүлэх зэрэг зорилт, арга хэмжээг аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. | |
| 1.3 | “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг хэрэгжүүлэх хүрээнд “Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийн төсөлд тусгах саналаа аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, албан бичгээр хүргүүлэх | - | Санал хүргүүлсэн байдал | - | Санал хүргүүлсэн байна | “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг хэрэгжүүлэх хүрээнд Хойд бүсийн өргөтгөсөн хуралдааны үеэр болох Засгийн газрын өргөтгөсөн хуралдаанд хэлэлцүүлэх Бүсийн хөгжилтэй холбоотой 8 төслийн саналыг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн ЗГХЭГ-т хүргүүлсэн. Мөн уг төслүүдийн санал болон холбогдох мэдээллийг Хойд бүсээс сонгогдсон 8 гишүүн, Зам тээврийн яам, Боловсролын яам, Эдийн засаг, хөгжлийн яам болон Хойд бүсийн хөгжлийн төв ТББ-д албан бичиг хүргүүлсэн. | 100% |
| 1.4 | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөөнд холбогдох салбарын бодлогыг тусгуулах, хэрэгжилтийг хангах | - | Арга хэмжээний гүйцэтгэлийн дундаж хувь | 94.2% | 90-ээс дээш хувь | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 96 арга хэмжээг тусган, хэрэгжүүлж байна. | 100% |
| 1.5 | Аймгийн хэмжээнд баримтлах хөгжлийн жилийн төлөвлөгөөг аргачлал маягтын цагалварын дагуу боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх | - | Цагалварын дагуу төлөвлөх, хэрэгжилтийн хувь | Цагалварын хуваариар батлуулсан. 2024 оны хэрэгжилт 92.3% | Цагалварын хуваариар батлуулах, хэрэгжилт 90-ээс дээш хувь | Монгол улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 05-р сарын 08-ны А/26 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөө боловсруулах аргачлал”-ын цагалварын дагуу Орхон аймгийн 2026 оны хөгжлийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | жилийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг байгуулан, мэргэжлийн байгууллагуудаас санал авах ажил хийгдэж байна. Эрдэнэт хотын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг гаргаж байна. | |
| 1.6 | Аймгийн хэмжээнд баримтлах таван жилийн үндсэн чиглэл, хөгжлийн жилийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг unelgee.gov.mn сайтад шивж оруулах | - | 01 дүгээр сард багтаах | Хуулийн хугацаанд гүйцэтгэсэн | - | unelgee.gov.mn сайтад 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний 10 салбарын үр дүн, 21 ТЕЗ-ын үр дүн, 52 хөтөлбөрийн үр дүн, 181 арга хэмжээний хэрэгжилтийг гарган хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэн хуулийн хугацаанд буюу 2025.03.17-ны өдөр 89.2%-тай тайлагнаж дууссан. Системд хараахан баталгаажуулалт хийгдээгүй байна. Мөн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 8 бүлгийн хүрээнд 8 салбарын үр дүн, 34 ТЕЗ-ын үр дүн, 63 хөтөлбөрийн үр дүн, 186 арга хэмжээг системд хуулийн хугацаанд оруулсан. | 100% |
| 1.7 | Шинэ сэргэлтийн бодлогын Хот хөдөөгийн сэргэлт зорилтыг хангах, төвлөрөлийг сааруулах зорилтын хүрээнд 2025 оны төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, хэрэгжүүлэх | 35.0 | Хүн амын өсөлтийн хувь<br><br>Төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувь | 3.2 %<br><br>100 хувьтай хэрэгжүүлсэн. | 2%<br><br>90-аас дээш хувьтай хэрэгжүүлэх | Шинэ сэргэлтийн бодлогын Хот хөдөөгийн сэргэлт зорилтыг хэрэгжүүлэх Улаанбаатар хотоос шилжин ирэх иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих “Хамтдаа Эрдэнэтэд хөгжье” хөтөлбөрийн хүрээнд аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын бага ангийн багш нараас ахисан түвшний магистрын сургалтад 59 багшийг хамрууллаа. 2025 оны 5-р сарын 06-ны өдөр “Бүтээлч-Ухаалаг-Тогтвортой” уриан дор “Хойт бүс-Эрдэнэт-2025” эдийн засгийн форумыг зохион байгуулсан. Форумаар Эрдэнэт хотыг 2036 он хүртэл хөгжүүлэх бодлогыг танилцуулан, Ухаалаг хот, Эрүүл оюунлаг хот, Цэвэр агаартай хот төслүүд, тэдгээрийн хүрээнд хэрэгжих 60 | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дэд төслийг танилцуулсан. Уг төслүүд хэрэгжсэнээр Орхон аймагт шилжин ирж буй иргэдэд бизнес эрхлэх, ажиллах, амьдрах таатай орчин бүрдэх юм. | |
| 1.8 | Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим системд сумдын хөгжлийн индексийн мэдээллийг 2024 оны байдлаар шинэчилж оруулах; www.ldi.nda.gov.mn | - | 03 дугаар сард багтаах | Хуулийн хугацаанд гүйцэтгэсэн | - | "Орон нутгийн хөгжлийн индекс" тооцох цахим систем өөрчлөгдөн https://ldi.regional.gov.mn/ болсон ба тус системд Баян-Өндөр, Жаргалант сумдын ерөнхий мэдээлэл болон индекс тооцох 31 төрлийн статистик мэдээллийг хуулийн хугацаанд оруулуулан, хянаж баталгаажуулсан. | 100% |
| 1.9 | Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын төслийг боловсруулах ажлыг зохион байгуулах | 30.0 | Хуульд заасан хугацаанд хэрэгжүүлсэн хувь | 100% | 11 дүгээр сарын 20-нд аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор ИТХ-д өргөн мэдүүлж, холбогдох байгууллагуудад хүргүүлж 100% хэрэгжүүлнэ. | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, 2026 оны төсвийн төсөлд тусгахаар нийт 20 төсөл арга хэмжээ төлөвлөн хөрөнгө оруулалтын удирдлага мэдээллийн системд шивж оруулснаас дээрх заалтад нийцсэн болон 2 шатны үнэлгээний шатандаа 18 төсөл арга хэмжээ байна. Үүнээс Сангийн яамны хөрөнгө оруулалтын цахим системд 2026 оны төсөвт тусгах нэгтгэлд 139,457.5 сая төгрөгийн 20 төсөл арга хэмжээ тусcанаас 25,9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл арга хэмжээ урд оноос шилжин хэрэгжих төсөл арга хэмжээ байна. Орхон аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн "Улс, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудит хийхтэй холбогдуулан 2024 оны хөрөнгө оруулалтаар батлагдсан төсөл арга хэмжээний мэдээ, тайланг хүргүүлсэн. | 100% |
| 1.10 | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн | - | Гүйцэтгэлийн хувь | 100% | Хяналт хийгдэж төсвийн жилд | 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 125.3 тэрбум төгрөгийн 266 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд хяналт тавих | | | | багтаан 100% хэрэгжүүлсэн байна. | 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар 236 төсөл арга хэмжээ буюу нийт худалдан авалтыг 88.7 хувийг зохион байгуулаад байна. Үүний үр дүнд гүйцэтгэгч шалгарсан 193, зарласан 3, тендер зарлаад амжилтгүй болсон-40, зураг төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар хүлээгдэж буй-21, шууд худалдан авахаар бэлтгэгдэж буй-9 төсөл арга хэмжээ байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 5 дугаар сарын байдлаар 72.5 хувийн биелэлттэй байна. | |
| 1.11 | Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулга, хэлэлцүүлэг зохион байгуулах, эрэмбэлэх, төлөвлөх, гүйцэтгэлд хяналт тавих, сурталчлах ажлыг зохион байгуулах. | - | Журмыг хангаж ажилласан хувь | 100% | Орон нутгийн хөгжлийн сангийн 2026 оны санал асуулга, хэлэлцүүлэг зохион байгуулж, эрэмбэлэх, төлөвлөх ажлыг гүйцэтгэх | 2026 онд аймгийн хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний урьдчилсан жагсаалт бэлтгэх ажлын хэсгийг Аймгийн Засаг даргын 2025 оны 05-р сарын 27-ны өдрийн А/396 дугаар захирамжаар батлуулсан. | 100% |
| **Зорилт-2: Салбарын бодлогын баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 2.1 | Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй томоохон үйлдвэрүүдтэй хамтран ажиллах ажлын төлөвлөгөөг нэгтгэн боловсруулах, батлуулах, тайланг холбогдох газарт хүргэх. | - | Хамтран ажиллах төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн тайлагнасан байна. | 3 үйлдвэрийн төлөвлөгөөний биелэлт тайлагнасан. | Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, тайлагнасан байна. | “Ачит-Ихт” ХХК, “Эрдмин” ХХК, “Зэс Эрдэнийн хувь”-тай байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр 2025 онд хамтраг ажиллах төлөвлөгөөг баталсан “Эрдмин” ХХК-тай 105 сая, “Ачит-Ихт” ХХК-тай 155.0 сая, Зэс эрдэнийн хувь ХХК-тай 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хамтран | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллах төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | |
| 2.2 | Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулах | - | Төлөвлөгөөний боловсруулалтын хувь | 5% | 50% | Орхон аймгийн "Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулах ажилд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцаас 1,3 тэрбум төгрөгийн төсөв батлагдаж, уг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын даалгаврыг шинэчлэн боловсруулахад орон нутгийн холбогдох байгууллагууд саналаа нэгтгэн тусгаж БХБЯамд хүргүүлэн 2024 оны 05-р сарын 22-ны өдөр Барилга, хот байгуулалтын сайд 2024/07 дугаартай даалгаврыг батласан. БХБЯамнаас гүйцэтгэгч байгууллага сонгон шалгаруулах үйл ажиллагааг 2 удаа зохион байгуулан 2024 оны 10 сарын 31-нд "Нью урбанизм" ХХК шалгарч 8 сарын хугацаанд гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажил 30 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна. | 70% |
| 2.3 | Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачлагын бодлого, төлөвлөлт, зохицуулалтыг орон нутагт хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 90% | 90-ээс дээш | Аймгийн Засаг даргын 2023 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн А/50 захирамжаар "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөл"-ийг төр, хувийн хэвшил, иргэний төлөөлөл бүхий 15 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж ОҮИТБСА-д хүргүүлсэн. | 100% |
| 2.4 | Салбаруудын сайдтай Засаг даргын хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангах, тайланг холбогдох газарт хүргэх | - | Гэрээний хэрэгжилтийн дундаж хувь | 90-ээс дээш | 90-ээс дээш | Салбарын сайдуудтай байгуулсан гэрээний эхний хагас жилийн биелэлтийг гаргаж байна. Хяналт, шинжилгээ-үнэлгээ хийлгэн хуулийн хугацаанд нь хүргүүлэх ажлыг зохион байгуулна. | 100% |

| СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: ДЭД БҮТЭЦ, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫГ ХАНГАХ | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт-1: Инженерийн хангамжтай орон сууц болон хувийн сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.** | | | | | | | |
| 1.1 | Инженерийн хангамжтай нийтийн болон амины орон сууцны хорооллуудыг барьж аймгийн орон сууцны санг нэмэгдүүлэх | Орон нутгийн төсөв Хувийн хэвшил | Ашиглалтад орсон орон сууцны айл өрх | 863 | 1000 | "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтаар 400 айлын "Уурхайчин-3" амины орон сууцны хорооллын барилга угсралтын ажил 60 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.<br><br>Мөн хувийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд нийтийн орон сууцны 7 төсөл Оюут, Чандмань Найрамдал, багуудад тус тус баригдаж байгаагаас 2025 оны хагас жилийн байдлаар 444 айлын орон сууц ашиглалтанд орсон. | 50% |
| 1.2 | Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа инженерийн шугам сүлжээний засвар шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэх ажлыг зохион байгуулах | Батлагдсан төсвийн хүрээнд | Ажлын гүйцэтгэлийн хувь | - | 100 | Аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалтын нийт 292 ажил хийгдэхээр төлөвлөгдсөнөөс 2025 оны хөрөнгө оруулалтаар шинээр 181 ажил, 2024 оноос он дамжин хийгдэх 111 ажил байна.<br><br>-Үүнээс: 2025 онд шинээр 181 ажлын гэрээ байгуулах мэдэгдэл (Орхон аймаг 116, Баян-Өндөр сум 48, Жаргалант сум 17) ирснээс ажил дууссан 17, 50 хувиас дээш гүйцэтгэлтэй 14, 50 хувь хүртэл гүйцэтгэлтэй 45 ажил гэрээний ажил эхлэх хугацаа болоогүй 12, гэрээ батлагдаагүй 93 ажил байна. 2025 оны гэрээ байгуулсан ажлуудад үе шатны хуваарийн дагуу ажлуудыг эхлүүлэн ажиллаж байгаа ба 8 ажил 7 дугаар сард, 3 ажил 8 дугаар сард эхлэх хуваарьтай бол бусад ажил эхэлсэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болон 6 дугаар сард эхлэхээр байна. ИШС-ний 5 ажил эхлээд 45% гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. | |
| 1.3 | Аймгийн хэмжээний хүчдэлийн уналтыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах | Батлагдсан төсвийн хүрээнд | Ажлын гүйцэтгэлийн хувь | - | 100 | Хотын цахилгаан хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэхэд шаардлагатай 35кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, шугам, сүлжээг өргөтгөн, ухаалаг удирдлагын систем нэвтрүүлж, цахилгаан хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 63 ажил төлөвлөн ажилласанаас 28 ажилд гэрээ хийгдэж, 33 ажил гэрээ хийгдэх шатандаа үргэлжилж байгаа бол 2 ажилд гүйцэтгэгч шалгараагүй байна. 63 ажлаас 4 ажилд ашиглалтад хүлээн авах ажлын хэсэг ажиллаж хүлээн авсан байна. | 100% |
| **Зорилт-2: Гэр хорооллын багуудын дахин төлөвлөлтийн иж бүрэн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, багийн төвүүд болон айл өрхийг төвлөрсөн шугам /халаалт, цэвэр бохир/-д холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 2.1 | Хот дахин төлөвлөн барилгажуулах ажлыг зохион байгуулах | 120.0 | Судлагдсан байршлын тоо | 3 | 4 | Аймгийн хэмжээнд Цагаанчулуут багт 11.9 га, Уурхайчин багт 1.3 га газарт дахин төлөвлөлтийг хийж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоолоор батлуулсан. Тус тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Уурхайчин багт 1.3 га газарт дахин төлөвлөлтийн ажил гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулан төсөл эхлүүлснээр хэрэгжилт 30 хувьтай, Цагаанчулуут багт 11.9 га талбайд дахин төлөвлөн барилгажих хэсэгчилсэн төлөвлөлтийн зураг төсөл хийгдэж байна. Дахин төлөвлөх үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хийлгэх ажлын хүрээнд Эрдэнэ багт 2.5 га<br><br>амины орон сууцны барих ажил 30 хувьтай. Баян-Өндөр сумын Хүрэнбагт Уурхайчин-1 хорооллын баруун талд амины болон цөөн давхар барилгын хэсэгчилсэн төлөвлөлтийг 10га талбайд хийлгэж байгаа ба зураг төсөл боловсруулах ажил 40 хувийн гүйцэтгэлтэй байна. | |
| 2.2 | Залуус хорооллын инженерийн шугам сүлжээний зураг төслийг боловсруулж батлуулах | 83.3 | Зураг төсөв боловсруулатын хувь | - | 100 | Залуус хорооллын инженерийн шугам сүлжээний зураг төслийг боловсруулах ажилд ОТЗТ ХХК 10 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Тус хэсгийн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн ажил удааширсантай холбоотой шугам сүлжээний зураг төсөлд техникийн нөхцөл олгогдохгүй ажил удааширч байна | 50% |
| 2.3 | Эрчим хорооллын барилгажилтын төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай зураг төслийг боловсруулах | 180.0 | Зураг төсөв боловсруулатын хувь | - | 100 | 2025 оны зөвлөх үйлчилгээний зардалд Эрчим хорооллын барилгажилтын зураг төслийг боловсруулахаар 100 сая төгрөгийг төлөвлөн зураг төсөл боловсруулах даалгаварыг боловсруулан худалдан авах ажиллагааны газарт хүргүүлээд байна. | 50% |
| 2.4 | Барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдалд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, паспортжуулах ажлыг үе шаттай зохион байгуулах | 100.0 | Тухайн жилд паспортжуулсан барилгын тоо | - | 2 | Барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдалд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, паспортжуулалт гэрчилгээжүүлэх ажлын даалгаврыг боловсруулан Аймгийн Засаг даргаар батлуулж худалдах, худалдан авах ажиллагаа хийгдэж байна. Энэхүү ажлын даалгаварт Баян-Өндөр сумын 2-р сургуулийн хичээлийн 1 байрны барилгын ашиглалтын төлөв | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байдалд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, паспортжуулах хийх ажил, Баян-Өндөр сумын 7-р сургуулийн барилгын ашиглалтын төлөв байдалд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, паспортжуулах хийх ажил, Баян-Өндөр сумын 16-р цэцэрлэг барилгын ашиглалтын төлөв байдалд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, паспортжуулах хийх ажил, Баян-Өндөр сумын 17-р цэцэрлэг барилгын ашиглалтын төлөв байдалд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, паспортжуулах хийх ажил, Баян-Өндөр сумын 18-р цэцэрлэг барилгын ашиглалтын төлөв байдалд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, паспортжуулах хийх ажил тусгасан. Тус ажлын хүрээнд дээрх барилгуудын ашиглалтын төлөв байдалд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, паспортжуулах ажил хийгдэнэ. | |
| **Зорилт-3: Ухаалаг тээврийн системд тулгуурласан хотын доторх нийтийн тээврийг хөгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлж, тээврийн төрлүүдийн харилцан уялдааг хангасан, өрсөлдөх чадвар бүхий аюулгүй, ая тухтай, зорчигч тээврийн үйлчилгээг үзүүлнэ.** | | | | | | | |
| 3.1 | Нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг системийг нэвтрүүлэх | - | Ухаалаг системийг нэвтрүүлэх ажлын хувь | 80 | 100 | Нийтийн тээврийн үйлчилгээнд цахим картын систем нэвтрүүлэх ажлын гүйцэтгэгчээр "Зэс арвид" ХХК шалгарч ажлыг эхлүүлснээр карт уншигч төхөөрөмж, хүн тоологч камер болон бусад дагалдах хэрэгслүүд, удирдлагын систем зэрэг 18 нэр төрлийн тоног төхөөрөмжийг нийлүүлэн ШУТП-д хүлээлгэн өгөөд байна. Нийтийн тээврийн төлбөрийн системийг үндэсний дата төвийн серверт суурилуулж, холболтын ажлын туршилт хийгдсэн. Тус | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилд орон нутгийн төсвийн 240.0 сая төгрөгийг төсөвлөсөн байна. | |
| 3.2 | Авто замтай уялдуулан нийтийн тээврийн маршрут чиглэлийг өөрчлөх, сайжруулах | - | Өөрчилж, шинэчлэлт хийсэн чиглэлийн тоо | 2 | 1 | Иргэдийн санал хүсэлтийн хүрээнд Аймгийн Засаг даргын А/959 дугаар захирамжаар Ч9 буюу Яргуйт-Хангай бүс худалдааны төв-2А хороолол-Авто вокзал-Хүлэг зах чиглэлийг шинээр байгуулан Хот тохижуулах газар хариуцуулан үйл ажиллагааг жигдрүүлээд байна. Тус чиглэлд стандарт шаардлага хангасан дунд оврын 4 автобус иргэдэд үйлчилж байна. Шинэ чиглэл байгуулсантай иргэдийн санал хүсэлтийн хүрээн аймгийн Засаг даргын А/958 дугаар захирамжаар Шанд чиглэлийн маршрутыг 15-р сургууль-Халуун ус буюу дунд замаар явахаар шинэчлэн байгуулсан. | 100% |
| 3.3 | Нийтийн тээврийн авто зогсоол буудлыг стандарт шаардлагын дагуу шинэчлэх, шинээр байгуулах | - | стандарт шаардлага хангасан нийтийн тээврийн үйлчилгээний автобусны буудлын тоо | 94 | Нэмэгдүүлсэн байна | 2024-2025 онд авто зам, замын байгууламжийн 43 ажил үргэлжлэн хийгдэж байна. Тус авто замын ажлуудын хүрээнд 80 гаруй авто зогсоол хийгдэх юм. | 50% |
| 3.4 | Нийтийн тээврийн үйлчилгээнд чанар хүртээмжийн судлагаа хийх | 4.0 | Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа хийгдсэн байдал | Судалгаа хийгдсэн. Иргэдийн сэтгэл ханамж 2.5 | Судалгаа хийгдсэн байна | Тухайн ажил ТББ-ын гэрээгээр хийгдэх байсан боловч төсөв батлагдаагүй. Сум болон багтай хамтран авто тээврийн төв зохион байгуулахаар ажиллаж байна. | 70% |
| **Зорилт-4: Аймгийн хэмжээнд хатуу хучилттай замын сүлжээ болон уулзваруудыг өргөтгөж, авто зам ашиглалтын үйлчилгээг сайжруулна.** | | | | | | | |
| 4.1 | Авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор | 11,734.2 | Хатуу хучилттай | 123.1 км | 130 км | 2024-2025 онд авто зам, замын байгууламжийн 43 ажил үргэлжлэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хатуу хучилттай авто замын сүлжээ болон уулзваруудыг өргөтгөх | | авто замын урт | | | хийгдэж байна. 2025-2028 онд аймгийн хэмжээнд хийгдэх авто зам, замын байгууламжийн 39 авто замын ажлын даалгавар, замын трассыг боловсруулан Төрийн худалдан авах ажиллагааны газарт 3, аймгийн Худалдан авах ажиллагааны газарт 30 авто замын зураг төсвийн зөвлөх үйлчилгээг зарлан гүйцэтгэгч шалгараад байна. | |
| 4.2 | Хот доторх авто замын нөхөөс, тэмдэг, тэмдэглэгээг үе шаттайгаар хийх | - | Хийгдсэн нөхөөс, тэмдэг, тэмдэглэгээний тоо хэмжээ | Нөхөөс 22618.3м2<br>Тэмдэг тэмдэглэгээ 53ш | Батлагдсан төсөвт багтаан хийсэн байна. | Хотын хэмжээний автозам эвдрэлийн судалгаа гаргаж, 26100 кг хүйтэн асфалтаар 217,2 м2 автозам, хаягдал асфальт боловсруулах төхөөрөмж ашиглан 13 м2 автозам, нийт 230,2 м2 автозамыг нөхсөн байна.<br>Автозамын босоо 25 ш тэмдэг, тэмдгэлгээг сэргээн засварласан. Хэвтээ тэмдэглэгээг тендер шалгараад компани шалгарсан байна. | 100% |
| 4.3 | Хот доторх явган хүний зам болон дугуйн замын хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдрах орчныг сайжруулах | 715.3 | Ашиглалтад авсан дугуйн болон явган зам | - | 6.2 км дугуйн зам ашиглалтад авсан байна | Хотын дотор болон амралт, зугаалгын бүсүүдэд явган хүн, унадаг дугуйн замыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2025 оны авто зам, замын байгууламжийн ажил хийхээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 57, Баян-Өндөр сумын хөрөнгө оруулалтаар 23, Жаргалант сумын хөрөнгө оруулалтаар 2 нийт аймгийн хэмжээнд 82 ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн. | 100% |
| **Зорилт-5: Орхон аймгийн газар зохион байгуулалтын 2021-2037 он хүртэлх 16 жилийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 5.1 | Аймгийн Газрын харилцааны талаар 2025 онд баримтлах үйл ажиллагааны чиглэлд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллах | - | Хэрэгжилтийн хувь | 91 хувь | Төлөвлөгөөний хэрэгжилт 90-ээс доошгүй хувийн гүйцэтгэлтэй байна. | Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан Аймгийн ИТХ-ын 2024 оны 02/12 дугаар тогтоолоор "Газрын харилцааны талаар 2025 онд баримтлах үйл ажиллагааны чиглэл"-ийг батлуулан 10 арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025 оны хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийх тусгай зөвшөөрөл бүхий 4 аж ахуйн нэгжээс газрын удирдлагын цахим системээр илгээсэн хот тосгон, бусад суурин газар болон ХАА-н зориулалтаар ашиглаж байгаа нийт 220 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 31.7га газрын хянан баталгааны тайлан, дүгнэлтийг хуулийн хугацаанд нь баталгаажуулсан.<br><br>Аймгийн ИТХ-ын тогтоолын дагуу Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт 4 байршил 3,01 га, Баян-Өндөр сумын Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 4 байршилд 0,02 га, Жаргалант сумын Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 12 байршил 10,28 га газарт цахим дуудлага худалдааг зохион байгуулахаар газрын биржийн цахим систем MLE.mn сайтад байршуулаад байна. Мөн малчдын хоршоонд эзэмшүүлэх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зорулалтаар 6 байршлын 24.7 га газрын төсөл сонгон шалгаруулах зарыг газрын биржийн системд байршуулсан. Erdenet.mn цахим сайтад Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн төлөвлөгөөг иргэд олон нийт танилцах боломжоор хангаан байршуулсан. Аймгийн Газрын харилцааны талаар 2025 онд баримтлах үйл ажиллагааны чиглэлд тусгагдсан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг 60 хувийн хэрэгжилттэй байна.<br><br>Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумдын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн судалгааг гарган эдэлбэр газрыг тогтоохтой холбоотой саналыг ГЗБГЗЗЕГ-т 02 дугаар сарын 13-ны өдрийн 492 дугаартай албан тоотоор хүргүүлээд байна. | |
| 5.2 | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх ажлыг зохион байгуулах | - | Боловсруулсан захирамжийн тоо | 208 | Газар эзэмшүүлэх, ашиглуулах, ажлыг зохион байгуулсан байна. | Газар хамтран өмчлөх эрх хүчингүй болгох тухай аймгийн Засаг даргын 10 удаагийн захирамжаар 54 иргэний хамтран өмчлөх эрхийг хүчингүй болголоо.<br><br>2024 онд Төсөвт байгууллага болон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын газар эзэмшүүлэх, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах, газар эзэмших эрхийн гэрчилгээ шилжүүлэх, хүчингүй болгох тухай нийт 123 удаагийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулан, баталгаажуулж газрын холбогдолтой асуудлыг нь шийдвэрлэсэн байна. | 100% |
| 5.3 | Газрын биржийн үнийн судалгаа, газар өмчлөх, эзэмших, ашиглах иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг газрын үнэлгээ, төлбөрийн цахим системд хамруулах | - | Бүртгэсэн нэгж талбарын тоо | Бүртгэсэн нэгж талбарын тоо 4000 | Бүртгэсэн нэгж талбарын тоо 4100 | Аймгийн ИТХ-ын тогтоолын дагуу Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт 4 байршил 3,01 га, Баян-Өндөр сумын Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 4 байршилд 0,02 га, Жаргалант сумын Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 12 байршил 10,28 га газарт цахим дуудлага худалдааг зохион байгуулахаар газрын биржийн цахим систем MLE.mn сайтад байршуулаад байна. 2025 оны 2-р улиралд 341 нэгж талбарын үнийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөрвүүлж, эдийн засгийн үнэлгээ хийсэн. Мөн малчдын хоршоонд эзэмшүүлэх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зорулалтаар 6 байршлын 24.7 га газрын төсөл сонгон шалгаруулах зарыг газрын биржийн системд байршуулсан. | |
| 5.4 | Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны дүгнэлтийг баталгаажуулж, гарсан дүгнэлтийн хүрээнд иргэн, аж ахйун нэгж байгууллагад зөвлөмж өгөх | - | Зөвлөмж өгсөн байдал | - | Гарсан дүгнэлтийн хүрээнд иргэн, аж ахйун нэгж байгууллагад зөвлөмж өгсөн байна | 2025 оны хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийх тусгай зөвшөөрөл бүхий 4 аж ахуйн нэгжээс газрын удирдлагын цахим системээр илгээсэн хот тосгон, бусад суурин газар болон ХАА-н зориулалтаар ашиглаж байгаа нийт 220 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 31.7га газрын хянан баталгааны тайлан, дүгнэлтийг хуулийн хугацаанд нь баталгаажуулсан. Дүгнэлтийн хүрээнд иргэн, аж ахйун нэгж байгууллагад зөвлөмжийг өгч ажилласан. | 100% |
| **Зорилт-6: ”Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.** | | | | | | | |
| 6.1 | Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах хүрээнд хэрэгжиж буй төслүүдийг бодлогын баримт бичигт тусгах, хэрэгжилтэд хяналт тавих | Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ | Төслүүдийн хэрэгжилт | Тухай бүр хяналт тавьж тайлан мэдээг авч ажилласан | Бодлогын баримт бичиг болон хамтын ажиллагааны гэрээнд тусгуулсан байна | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт уул уурхайн чиглэлээр 2 зорилтын хүрээнд 5 арга хэмжээ тусгагдсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар 45 хувьтай хэрэгжсэн байна. | 100% |
| СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ, АРГА ЗҮЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ | | | | | | | |
| **Зорилт-1: Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрт хамрагдаж хөнгөлөлттэй зээл, батлан даалтын үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлнэ.** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1 | Өрхийн үйлдвэрлэл болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих чиглэлээр холбогдох газруудтай хамтран ажиллах | - | Дэмжин ажилласан өрхийн болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо | | Холбогдох арга хэмжээг авч дэмжин ажилласан байна. | ХХААХҮЯ, ЖДҮГ, аймгийн ЗДТГ-тай “Ерөнхий нөхцөл тохиролцох, хамтран ажиллах гурван талт гэрээ” байгуулж, орон нутгийн төсвөөс 300,000,000 /Гурван зуун сая/ төгрөгийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4, 16.6-т заасны дагуу тухайн орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, хөнгөлөлттэй зээл олгох зориулалтаар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн дансанд байршуулахаар гэрээ байгуулж санхүүжилтийг шилжүүлсэн. Аймгийн ЗДТГ, ХААН, Капитрон банктай хамтран ажиллах гэрээний дагуу зээл хүссэн иргэн, аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн дэмжигдсэн төслүүдийг банкуудад уламжилсан. Тайлант хугацаанд сүүний чиглэлийн үнээ худалдан авах, өндөг үйлдвэрлэл, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх, махны чиглэлийн үхэр бордох газар байгуулах зэрэг төслүүдийг дэмжсэн. | 90% |
| 1.2 | Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээл хүссэн өргөдөл, материалыг хүлээн авах, арилжааны банкуудад уламжлах | 600.0 | Дэмжсэн төслийн тоо | Аймгийн ЖДҮ сангаас 5 зээл олгогдсон. | Зээл хүссэн өргөдлийг хүлээн авч ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж холбогдох газарт хүргүүлсэн байна. | ”Орхон аймгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээл олгох журам”, “Хөнгөлөлттэй зээл олгох шийдвэр гаргах ажлын хэсэг”-ийн аймгийн Засаг даргын 2024 оны А/145 дугаар захирамжаар батлуулсан. Жижиг, дунд болон өрхийн бичил үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор ХААН, Капитрон, Төрийн банктай байгуулсан гэрээний | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хугацаа дууссантай холбогдуулан гэрээ сунгах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээр гэрээний төсөл, журмын хамт хүргүүлснээр ХААН, Капитрон банкууд гэрээг 5 жилийн хугацаатайгаар сунгасан.<br><br>Төрийн банктай байгуулсан гэрээг банкны зүгээс сунгах боломжгүй болсон тул тус банк дахь хөрөнгийг татан авч байршуулах асуудлыг хэлэлцэх ажлын хэсэг аймгийн Засаг даргын 2025 оны А/138 дугаар захирамжаар байгуулагдаж асуудлыг хэлэлцэн ХААН, Капитрон банкуудаас санал авч ХААН банктай хамтран ажиллах гэрээнд аймгийн ЗДТГ-аас Тусгай зориулалтын санд 300.0, банкаас 300.0, нийт 600.0 сая төгрөг, Капитрон банктай хамтран ажиллах гэрээнд аймгийн ЗДТГ-аас Тусгай зориулалтын санд 310.0, банкаас 310.0, нийт 620.0 сая төгрөг байхаар тусгаж нэмэлт өөрчлөлт оруулан гэрээ байгуулсан.<br><br>Аймгийн ЖДҮ эрхлэгчдийг дэмжих сангаас зээл хүссэн хүсэлтүүдийг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж 5 төслийг дэмжин банкинд уламжилсан. Одоогоор явган замын хавтан үйлдвэрлэх тоног төхөөрөмж худалдан авах чиглэлийн төсөлд 58.9 сая төгрөгийн зээл олгогдож бусад төсөл судлагдаж байна. | |
| **Зорилт-2: Орон нутгийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг дэмжинэ.** | | | | | | | |
| 2.1 | "Эрдэнэтэд үйлдвэрлэв" төвийн | 3,582.0 | Барилгын ажлын явц | - | 50% | "Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөр"-ийг | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | барилгыг ашиглалтад оруулж, орон нутгийн бизнес эрхлэгчдийн борлуулалтыг нэмэгдүүлэх | | | | | аймгийн ИТХ-ын 2023 оны 14/02 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд байгуулах "Эрдэнэтэд үйлдвэрлэв төв"-ийн худалдаа үйлчилгээний барилгын зураг төсөв хийх тендерт "Эрдэнийн хүчит суурь" ХХК шалгарч, барилгын зураг төсвийг боловсруулан хүлээлгэн өгсөн. Мөн барилга барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт “Сэнгүн констракшн” ХХК шалгаран ажил гүйцэтгэж байна. | |
| 2.2 | Мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах | - | Хамтран ажилласан байгууллагын тоо | 5 байгууллагтай хамтран ажилласан | 1 ээс доошгүй байгууллагатай холбогдох чиглэлээр хамтран ажилласан байна. | Салбарын чиглэлээр холбогдох төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж байна. Тайлант хугацаанд Тогоочдын холбоо ГҮТББ-тай хамтран Монгол үндэсний болон орон нутгийн онцлогтой уламжлалт хоол, идээ ундааны технологийг түгээн дэлгэрүүлэх, салбарын ажилтан, ажиллагсдын чадамж, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Монгол үндэсний хоол, идээ ундааны “Аймгийн аварга тогооч” шалгаруулах уралдааныг зохион байгуулсан.<br><br>Иргэний нийгмийн байгууллага болон төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх ажлын жагсаалтад туссан хүнсний худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагааг стандарт шаардлага хангуулах, хяналт тавих ажлын хүрээнд сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлаад байна. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт-3: Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийг түшиглэн боловсрол эрдэм, шинжилгээ, үйлдвэрлэлийн уялдаа холбоог бий болгон, сургалтын чанарыг дээшлүүлэх, оюутан суралцагчдын бүтээлч байдлыг хөгжүүлнэ.** | | | | | | | |
| 3.1 | Бизнес эрхлэгчдэд инновац нэвтрүүлэх зөвлөгөө өгөх, инновацын төсөл бүртгүүлэх | Улс,орон нутгийн төсөв | Инновац нэвтрүүлсэн бизнес эрхлэгчийн тоо | 3 | 3 | Хойд бүс-Эрдэнэт 2025 эдийн засгийн форумд Эмпасофт технологийн сургуулийн гүйцэтгэх захирал О.Энхжин, Women in tech Mongolia -ын захирал Н.Энхсайхан нар урилгаар оролцон “Квант эрин ба супер оюун”, “Хиймэл оюун” сэдэвт бизнес эрхлэгчдэд чиглэсэн сонирхолтой илтгэлүүдийг тавьж инноваци нэвтрүүлэх талаар зөвлөгөө өглөө.<br>Рийч органик косметик, Ган компасс, Стеам сургалт, Экора грийн гоулд, Ойстер гровинг субстрат, Бидэрт манхан, Талхны цех, Пенофасад, Мөөг кластер, Эко будаг гэсэн нийт 9 бизнес эрхлэгчид оффис, үйлдвэрлэлийн нийт 1,200м2 ажлын байр ашиглуулж, улирал тутамд сургалт, арга хэмжээнд оролцуулан ажиллаж байна. Мөн иргэдэд Бизнес ширээгээр тасралтгүй зөвлөгөө өгч, бизнес ширээ, кластер, стартап 3 цахим систем бий болгохоор мэдээлэл боловсруулж байна. | 100% |
| СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫГ ХАНГАХ | | | | | | | |
| **Зорилт-1: Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлээр хангана**. | | | | | | | |
| 1.1 | Хүнс, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг чадавхжуулах, хөгжүүлэх | 30.0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Уралдаан-2, сургалт-2 зохион байгуулсан | 5 | Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг чадавхжуулах, хөгжүүлэх ажлын хүрээнд монгол үндэсний болон орон нутгийн онцлогтой уламжлалт хоол, идээ ундааны технологийг түгээн дэлгэрүүлэх, салбарын ажилтан, ажиллагсдын чадамж, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Монгол үндэсний хоол, идээ ундааны “Аймгийн аварга тогооч” шалгаруулах уралдаан, “Erdenet | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | food festival" хоолны уралдаан, шоу үзүүлбэрийг зохион байгуулж, орон нутгийн төсвөөс 7.0 сая) төгрөг зарцуулсан. Иргэдийн хүнсний аюулгүй байдлыг хангах, чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд стандарт, техникийн зохицуулалтыг мөрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, HACCP болон ISO:22000 стандартыг үйлдвэрүүдэд нэвтрүүлэх ажил зохион байгуулж орон нутгийн төсвөөс 25.0 сая төгрөг зарцуулан ажиллаж байна. | |
| 1.2 | Хүн амын хаврын хэрэгцээнд нөөцийн мах бэлтгэн борлуулах аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, тайлагнах | 400.0 | Гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, тайлагнах | Гэрээ байгуулж, хяналт тавьж ажилласан. | Хүн амын хаврын хэрэгцээнд нөөцийн мах бэлтгэн борлуулах, хяналт тавих ажлыг зохион байгуулна. | Аймгийн жишсэн дундаж нийт хүн амын 2025 оны хаврын махны хэрэгцээг 90 хоногоор тооцоход 926.8 тонн малын мах хэрэгцээтэй бөгөөд үүний 21.5 хувь буюу 200 тонн махны нөөц бүрдүүлэхээр төлөвлөсөн.<br><br>Нөөцөд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах нь MNS 2456:2009, MNS 2457:2009 стандартын шаардлага хангасан байх ба махны нийт жингийн 55 хувь буюу 110 тн үхэр, 40 хувь буюу 80 тн хонь, 5 хувь буюу 10 тн ямааны мах байх бөгөөд ангилан савласан байдлаар худалдаанд нийлүүлэх сонгон шалгаруулалтад Эрдмийт ХХК шалгарч "Мах бэлтгэх, хадгалах, борлуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урамшуулал олгох" гэрээ байгуулсан. Нөөцийн махыг 2025 оны 03 сарын 15-ны өдрөөс эхлэн 06 сарын 05-ны өдрийг дуустал хугацаанд 30-аас доошгүй цэгээр худалдан борлуулж | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үхрийн мах 1 кг нь 12300, хонь 10300, ямаа 8300 төгрөгөөр худалдаалах ажлыг зохион байгуулсан. 06 сарын 05-ны байдлаар 6.7 тн махны үлдэгдэлтэй бөгөөд борлуулалт 96.7 хувь, үхэр 4.6 тн, хонь 2.1 тн үлдэгдэлтэй, ямааны мах дууссан байна. | |
| **Зорилт-2: Хүнсний сүлжээний бүх шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангана.** | | | | | | | |
| 2.1 | "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх Орхон аймгийн 2022-2027 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | 35.0 | Хэрэгжилтийн хувь | 85.7 хувь | Хэрэгжилт 90 хувиас доошгүй | Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг Орхон аймагт 2022-2027 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12/02 дугаар тогтоолоор батлуулж, 23 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэ онд тус төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулалтын 24 ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт тусган ажиллаж байна. "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний Орхон аймгийн 2022-2027 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 2025 оны аймгийн төсөвт 35.0 сая төгрөг батлагдсан. "Атар-4" тариалангийн тогтвортой аяны хүрээнд хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлээс газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 1 аж ахуйн нэгж, 2 иргэн эргэлтийн хөрөнгийн 375.0 сая төгрөг, эрчимжсэн мал аж ахуй | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрхлэгч 2 иргэн 100.0 сая төгрөг, нийт 1 аж ахуйн нэгж, 4 иргэн 475.0 сая төгрөгийн зээл олгогдож, ХХААГ зээлдэгчидтэй хяналтын гэрээ байгуулсан. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд стандарт, техникийн зохицуулалтыг мөрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, HACCP болон ISO:22000 стандартыг үйлдвэрүүдэд нэвтрүүлэх замаар иргэдийн хүнсний аюулгүй байдлыг хангах, чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулахаар орон нутгийн төсвөөс 25.0 сая төгрөгийн санхүүжилт батлуулан ажиллаж байна. Аймгийн жишсэн дундаж нийт хүн амын 2025 оны хаврын махны хэрэгцээг 90 хоногоор тооцоход 926.8 тонн малын мах хэрэгцээтэй бөгөөд үүний 21.5 хувь буюу 200 тонн махны нөөц бүрдүүлэхээр төлөвлөсөн.<br><br>Нөөцөд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах нь MNS 2456:2009, MNS 2457:2009 стандартын шаардлага хангасан байх ба махны нийт жингийн 55 хувь буюу 110 тн үхэр, 40 хувь буюу 80 тн хонь, 5 хувь буюу 10 тн ямааны мах байх бөгөөд ангилан савласан байдлаар худалдаанд нийлүүлэх сонгон шалгаруулалтад Эрдмийт ХХК шалгарч үхрийн мах 110 тонн, хонины мах 80 тонн, ямааны мах 10 тн, нийт 200 тонн махыг ангилж, савласан байдлаар нийлүүлж байна. Тус ажилд орон нутгийн төсвөөс 400.0 сая төгрөг зарцуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2 | Согтууруулах ундаа худалдах, үйлчилгээ эрхлэх хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг хүлээн авч ажлын хэсэгт танилцуулах, холбогдох шийдвэрийг аж ахуйн нэгжүүдэд хүргэх | - | Хүлээн авсан хүсэлтийн тоо | 524 | Хүсэлтийг шийдвэрлэн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна. | Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид 2023 оны 11 дүгээр сарын байдлаар согтууруулах ундаа худалдах 320, үйлчлэх 112, нийт 432 цэг байсан. Тайлант хугацаанд согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэг 109, худалдах цэг 350, нийт 414 цэг байна. Зургаан сараас дээш хугацаагаар тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа явуулаагүй 5 цэгийн тусгай зөвшөөрлийг цуцалсан.<br><br>Зөвшөөрлийн тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжүүдийг мэдээллээр ханган ажиллаж байна. ХХААХҮ-ийн сайдын 2023 оны А/419 дүгээр тушаалаар согтууруулах ундаа худалдах, үйчлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдэд тавигдах шаардлага батлагдсантай холбогдуулан холбогдох хууль, тогтоомж, тушаал, бүрдүүлэх материалын талаар аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл тогтмол хүргэж байна.<br><br>Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг https://e-business.mn/ системээр хүлээж авч, ажлын хэсгийн хурлыг 3 удаа хийж, тусгай зөвшөөрөл олгогдсон аж ахуйн нэгжүүдээр улсын тэмдэгтийн хураамж | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлүүлэн, тусгай зөвшөөрлийг цахимаар хүргэж байна.<br><br>Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх зөвшөөрөл олгоход хураах улсын тэмдэгтийн хураамжийн орлогын мэдээг гаргаж СТСХ-т хүргүүлэв. 2022 онд 55.3, 2023 онд 49.7, 2024 онд 404.5 сая төг, 2025 оны хагас жилийн байдлаар 36.5 сая төгрөг орон нутгийн төсөвт төвлөрсөн байна. | |
| 2.3 | Хүнсний үйлдвэрүүдэд (HACCP), ISO:22000 стандарт нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх | 30.0 | Нэвтрүүлсэн байгууллагын тоо | 5 | 3 | Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд стандарт, техникийн зохицуулалтыг мөрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, HACCP болон ISO:22000 стандартыг үйлдвэрүүдэд нэвтрүүлэх замаар иргэдийн хүнсний аюулгүй байдлыг хангах, чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах ажилд орон нутгийн төсөвт 25.0 сая төгрөг тусган аймгийн Засаг даргын 2025 оны А/473 дугаар захирамж гаргуулан ажиллаж байна. | 70% |
| 2.4 | Хүнсний сүлжээний бүх үе шатанд чанар, аюулгүй байдлыг дээшлүүлэн, хяналт тавьж ажиллах | - | Хяналтад хамрагдсан объект, хяналт шалгалтын тоо | 556 | 657 | 2025 оны эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөт шалгалт 45, төлөвлөгөөт бус 30, урьдчилан сэргийлэх шалгалт 176, нийт 251 объектод хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар нийт 456 зөрчил илрүүлснээс газар дээр нь мэргэжил арга зүй, зөвлөмж, зөвлөгөө өгч 320 зөрчил буюу 70 хувийг арилгуулсан. Илэрсэн зөрчилтэй холбогдуулан 114 заалт бүхий 15 албан шаардлага хүргүүлэн, тодорхой | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хугацаатайгаар хэрэгжилтийг хангуулан ажилласан. | |
| **Зорилт-3: Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалангийн хүрсэн түвшинг тогтворжуулан хөгжүүлнэ.** | | | | | | | |
| 3.1 | Газар тариалангийн ажлыг технологит хугацаанд гүйцэтгүүлэх | 3.0 | Тариалсан тайлбай | Мэргэжил арга зүйгээр хангаж нийт 5292 га-д тариалсан | Мэргэжил арга зүйгээр хангаж, өмнөх оноос бууруулахгүй | Аймгийн хэмжээнд энэ онд нийт 5156 га талбайд тариалалт хийхээр төлөвлөсөн. 2025 оны 06 сарын 05-ны байдлаар улаан буудай 3649 га, төмс 132 га, хүнсний ногоо 166.1 га, тосны ургамал 746 га, нийт 4693.1 га талбайд тариалалт хийж, 91.0 хувьтай байна. Хаврын тариалалтыг технологийн хугацаанд чанартай гүйцэтгэх ажлыг шуурхай зохион байгуулах, тариалалтын чанарыг соёололтоор нь хүлээн авах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Тус ажилд орон нутгийн төсвөөс 775.000 төгрөг төсөвлөсөн. | 100 |
| **Зорилт-4: Үр тариа, тэжээл, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалангийн талбай, нэгжээс авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| 4.1 | Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | 50.0 | Хамрагдсан өрхийн тоо | 500 өрх | 500 өрх | "Өрхийн тариалалтыг дэмжих" хөтөлбөрийн хүрээнд төмс, хүнсний ногооны үр хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох, сургалт хийх ажилд шаардагдах 50.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусган ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд 500 өрхөд 30 тн төмсний үр, 500 ширхэг, 4 төрлийн хүнсний ногооны үрийн багц олгосон. 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд төлөвлөгөөнд 9 арга хэмжээ тусган дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд:<br>1.Төмс, хүнсний ногооны үрийн дэмжлэгт Баян-Өндөр сумын 500 өрхийг хамруулан, сургалт арга зүйгээр хангасан. Дэмжлэгт хамрагдсан өрхүүдэд 250 м.кв талбайд тарихаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тооцож үр олгосон нь нийт 12.5 га талбайд төмс, хүнсний ногоо тариалсан.<br>2. Хүлэмжийн тариалалтыг дэмжих зорилгоор орон нутгийн төсвөөс 6*10 м харьцаатай 50 ширхэг хүлэмжийг худалдан авч, олгох ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>3. Жаргалант сум нь төмс, хүнсний ногооны үр шинэчлэх зорилгоор сумын төсвөөс 79.1 сая төгрөг шийдвэрлэсэн. Тус ажлын хүрээнд төмсний үр 30 тн, шар луувангийн үр 100 кг, шар манжингийн үр 50 кг, хүрэн манжингийн үр 50 кг, урт сонгины үр 10 кг-ыг тус бүрийн үнийг 80 хувийн хөнгөлөн иргэдэд олгосон. Үүний үр дүнд 25 га талбайд төмс, 32 га талбайд шар лууван, 17 га талбайд шар манжин, 10 га талбайд хүрэн манжин, 2 га талбайд урт сонгино тарих үр олгож дэмжлэг үзүүлсэн. | |
| **Зорилт-5: Малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ.** | | | | | | | |
| 5.1 | "Малын эрүүл мэнд"-ийг хамгаалах чиглэлээр төлөвлөгдсөн ажлыг гүйцэтгэх | 40.0 | Хэрэгжилтийн хувь | 96.8 хувь | Хэрэгжилт 90-ээс доошгүй хувь байна | Мал сүргийг 2025 онд халдварт өвчнөөс эмчлэн урьдчилан сэргийлэх арга хэмжээний дархлаажуулалтын төлөвлөгөө, шимэгчтэх өвчнөөс сэргийлэх болон ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээний төлөвлөгөө, адууны тандалт шинжилгээ хийх төлөвлөгөөг аймгийн Засаг даргын захирамжаар батлуулан, орон нутгийн төсвийн 100.8 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэн ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мал, амьтныг гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулахад орон нутгийн төсвөөс гарахаас урьдчилан сэргийлж өвөлжөө, хаваржааны ойр орчмын зудад хорогдсон малын сэг, зэмийг устгах, урьдчилан сэргийлэх халдваргүйтгэлийн арга хэмжээг цаг хугацаанд нь зохион байгуулан ажиллаж байна. | |
| 5.2 | Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх | 105.0 | тн | Аймаг 20тн өвс, 77.5 тн тэжээл бэлтгэсэн. | Өмнөх оноос бууруулахгүй | Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж батлуулахаар ажиллаж байна. Өвөлжилт, хаваржилтын бэлэн байдлыг хангах зорилгоор Баян-Өндөр сум өвс 80 тн, тэжээл 40 тн /100.0 сая.төг/, Жаргалант сум өвс 50 тн, тэжээл 30 тн /72.0 сая.төг/, аймгийн аюулгүйн нөөцөд өвс 60 тн, тэжээл 42.5 тн /105.0 сая.төг/, нийт 277.0 сая төгрөгөөр өвс 190 тн, тэжээл 112.5 тн бүрдүүлэхээр ажиллаж байна.<br>Засгийн газрын тогтоолоор батлагдсан төлөвлөгөөний дагуу аймаг, сумын аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг 100 хувь бэлтгэнэ. “Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө”-ний хүрээнд малчдын түвшинд 17500 тн байгалийн хадлан бэлтгэ.<br>Үүнээс: Баян-Өндөр сум-9500 тн, Жаргалант сум-8000 тн Малчид өвөлжөө, хаваржааны бууцны хөл газарт ногоон тэжээл тариалж тэжээлийн үйлдвэрлэлийг 10-12 хувиар нэмэгдүүлнэ. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.3 | Эрчимжсэн мал аж ахуй, туслах аж ахуй эрхлэгчдийг зээлийн бодлогоор дэмжих, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх | - | Дэмжлэгт хамрагдсан эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид | 4 | 2 | “Атар-IV” тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг улсын хэмжээнд эрчимжүүлэн хэрэгжүүлэхээр Засгийн газрын 47-р тогтоол батлагдан гарсан. Уг аяны хүрээнд Засгийн газрын хүүгийн дэмжлэгтэй, хөнгөлөлттэй зээлд хамрагдах эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 19, туслах аж ахуй 2, тэжээл үйлдвэрлэлийн чиглэлээр 1 иргэний мэдээллийг хүргүүлсэн. Ингэснээр хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлээс эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 2 иргэнд 100.0 сая төгрөгийн зээл олгогдож, ХХААГ зээлдэгчидтэй хяналтын гэрээ байгуулсан. | 100% |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫГ ХАНГАХ** | | | | | | | |
| **Зорилт-1: Гэр хороололд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлэх, усны зөв хэрэглээний талаар бүх нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.** | | | | | | | |
| 1.1 | Хот, суурин газрын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлж, усны нөөц бохирдож, хомсдохоос сэргийлэх | 5.0 | Хамгаалалтын бүсийн үйл ажиллагаа | 4 хамгаалалтын бүс ажиллаж байна | 4 хамгаалатын бүсийн үйл ажиллагааг сайжруулна | Орхон-Чулуут голын сав газрын захиргаатай хамтран усны ерөнхий химийн, нянгийн, фторын болон хүнд металын шинжилгээнүүдийг байгаль орчны итгэмжлэгдсэн лабораторит 2025 оны 08 дугаар сард хийлгэнэ. Жаргалант сумын ЗДТГ-аас Зүүн булгийн эх орчмыг хамгаалах, тохижуулах ажлыг ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа “Түмэн өлзий дүүрэн дэлгэрэх” нөхөрлөлтэй хамтран зохион байгуулахаар гэрээ байгуулж байна. | 100% |
| 1.2 | Хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн усыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжих. | 39.8 | Дэмжсэн хувийн хэвшлийн тоо | - | 2 | Орхон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй автомашин угаалгын газруудад Усны тухай хуулийн хэрэгжилт хэрхэн хангагдаж байгааг шалгах, хаягдал ус дахин боловсруулах шийдлийг тодорхойлох судалгааны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажлыг аймгийн Байгаль орчны газар, Баян-Өндөр сумын ЗДТГ, "Эрдэнэт Ус ДТС" ОНӨХК хамтран зохион байгуулж дууслаа.<br>Хяналт шалгалт, судалгааны ажлын хүрээнд нийт 27 автомашин угаалгын газар хамрагдсан бөгөөд инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон 22, усны асуудлаа зөөврөөр шийдвэрлэдэг 5 газар бүртгэгдлээ. Дийлэнх газрууд нь саарал усыг дахин ашиглах, дэвшилтэт технологи судалсан боловч нэвтрүүлж эхлээгүй, өөрсдийн боломжинд тулгуурлан Монбет, Хурд, Сархиа зэрэг автомашин угаалгын газрууд нь угаалгаас гарсан бохир усыг тунгааж, зөвхөн гадна угаалгад дахин ашиглаж байна. | |
| 1.3 | Хөрсний бохирдолыг бууруулах ажлыг зохион байгуулах | 35.0 | Зохион байгуулсан ажлын тоо | 2 | 2 | БОУАӨЯамны салбарын хяналтын газрын ерөнхий байцаагчийн баталсан "Хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр энгийн болон аюултай хог хаягдал хадгалах, ашиглах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх 01/06 дугаартай удирдамжийн хүрээнд Орхон аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 51 обьектыг хамруулан гүйцэтгэлээ. Тус шалгалтаар нүхэн жорлон ашиглаж байсан 10 үйлчилгээ газарт улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлэн гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаж байна. Мөн энгийн болон аюултай хог хаягдлын хадгалалт, устгалын үйл ажиллагаатай холбоотой илэрсэн дутагдлыг арилгуулхаар 11 объектод 45 заалттай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | албан шаардлага хүргүүлж, Хог хаягдлын тухай хууль зөрчсөн 9 үйлчилгээний газар, 2 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу нийт 2.800.000 төгрөгний торгууль ноогдуулан ажиллалаа. | |
| **Зорилт-2: Агаарын бохирдлыг бууруулах боломжит судалгааг хийж төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологийг бодлогоор дэмжинэ.** | | | | | | | |
| 2.1 | Аймгийн хүлэмжийн хийн тооллого зохион байгуулах | - | Хүлэмжийн хийн ялгарлыг тооцсон байдал | - | Хүлэмжийн хийн ялгарлыг тооцсон байна | Аймгийн хэмжээнд хүлэмжийн хийн шингээл ба ялгарал тооцуулах ажлын даалгаврыг болосруулсан. Зөвлөх үйлчилгээгээр хүлэмжийн хийн тооллого хийлгэх байсн боловч НҮБХХ-өөс Хүртээмжтэй ногоон хот" төсөл хэрэгжих гэж буйтай холбоотой түр хойшилсон. Нэгдсэн үндэсний байгууллагын Swich asia хөтөлбөрийн хүрээнд Эдийн засгийн ногоон шийдэл төслийн хүлэмжийн хийн чөлөөт зах зээлийн тухай мэдээлэл олгох сургалтад Сэлэнгэ голын сав газрын захиргаа, Сум дундын ойн анги, Баян-Өндөр сумын ЗДТГ зэрэг байгууллагуудын төлөөллийг хамрууллаа. | 50% |
| 2.2 | Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 85% | 87% | Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах хөтөлбөрийг 2024-2031 оны хооронд 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр шинэчлэн боловсруулж, аймгийн ИТХ-ын 2024 оны 18/04 дүгээр тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна.<br>Үүнд:<br>Цагаан тоосны дэгдэлтийг бууруулах, зорилгоор Кальцийн хлорид бодисыг хуурайгаар болон Hydroseeder PB80100 төхөөрөмжөөр тогтмол цацахаас гадна технологийн аргуудыг хослуулан тоос | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | идэвхтэй дэгддэг талбайд тогтмол цацаж байна.<br>Цагаан тоосны нөлөөллийн бүсийн иргэдийн эрүүл мэндийн үзлэгт 375 иргэн хамрагдсан.<br>Хаягдлын аж ахуйг нүүлгэн шилжүүлэхтэй холбогдуулан шинээр баригдах хаягдлын санг Орхон аймгийн Жаргалант сум, Булган аймгийн Орхон сумын нутагт нийт 7046.15 га талбайг сонгож, аймгийн ИТХ-ын 2024 оны 18/05 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны 116 дугаар тогтоолоор тус тус улсын тусгай хэрэгцээнд авч, газрын асуудлыг шийдвэрлүүлсэн.<br>Баяжуулах үйлдвэрийн шинэ хаягдал хураах сангийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгчээр Австрали улсын ATC Williams компани 2025-2028 онд гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна | |
| 2.3 | "Цэвэр агаартай хот" төслийг боловсруулан хэрэгжүүлэх | 1600.0 | Төслийн явц | - | Төсөл боловсруулсан байна | Аймгийн Засаг даргын 2025 оны А/65 дугаартай захирамжаар Цэвэр агаартай хот төслийг боловсруулах, үе шаттайгаар хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг нийт 4 удаа хуралдсан.<br>Эрдэнэт ШУТП-ын захирал Г.Энхбаяр Цэвэр агаартай хот төслийг ажлын хэсгийн гишүүд болон Засаг даргад танилцуулсан. Тухайн хурлаас өгсөн үүрэг даалгавар, чиглэлийн дагуу төслийг ахин сайжруулахаар ажиллаж байна. Мөн ХББЗА-наа ШУТИС-ийн Эрчим хүчний сургуулийн багш нарын бүтээсэн загварчлалыг 2025 оны 03 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар сарын 07-нд ажын хэсгийн гишүүдэд танилцуулсан. | |
| **Зорилт-3: Ногоон-Эрдэнэт төслийг хэрэгжүүлэн, аймгийн ногоон байгууламж, мод бутны хэмжээг нэмэгдүүлнэ** | | | | | | | |
| 3.1 | “Ногоон Эрдэнэт” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, мод тарих олон талт ажлыг зохион байгуулах | 20.0 | Тарьсан модны тоо сая.ш | 4.8 | 5.6 | Аймгийн Засаг даргын 2025 оны “Бүх нийтээр мод тарих хаврын ажил зохион байгуулах тухай” А/360 дугаар захирамжаар мод тарих ажлын төлөвлөгөөг батлуулан, төлөвлөгөөний дагуу ажлуудыг зохион байгуулан ажиллалаа. Жаргалант сумын нутаг дэвсгэр болон Баян-Өндөр сумын Дэнж баг, Тарлан толгойн энгэрт 17.5 га-д ойн төгөл, Вокзалын ойн зурвас 2,5 га, Хангал гол, Эрдэнэт хаалга орчим, Эрдэнэт голын эх, Хүрэнбулагийн ам зэрэг газруудад 48,3 га талбай газарт нийт 141.200 ширхэг мод тарих олон талт ажлыг зохион байгууллаа. Мод тарих ажлыг зохион байгуулснаар нийт өссөн дүнгээр таримал модны хэмжээг 4.980.886 ширхэгт хүргэж Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн нэгдүгээр үе шатны хугацааг 100 хувьд хүргээд байна. Мод тарих хүсэлтэй иргэдийн хэрэгцээг хангах зорилгоор мод бут, сөөгний тарьц, суулгацын үзэсгэлэн худалдааг зохион байгуулах, мод тарих хар шорооны нөөцийг бүрдүүлэх болон усалгааны систем зэрэг бэлтгэл ажлуудыг хانган ажилласан.<br><br>Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд мод тарих нийт талбайн зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх, Тарьсан модоо арчилъя аяныг зохион байгуулах, “Өрх бүр 5 ширхэг” мод арга хэмжээг зохион байгуулах, Гэр | 96% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хорооллын айл өрхүүдэд тарих модны нарийвчилсан судалгаа хийх зэрэг 18 арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. | |
| 3.2 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Ногоон Эрдэнэт" хөтөлбөрийн хүрээнд хэрэгцээтэй тарьц, суулгацын нөөцийг бүрдүүлэх | - | Бүрдүүлсэн тарьц, суулгацын нөөц | 2.0 сая | 2.0 сая | Аймгийн хэмжээнд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэд, аж ахуйн нэгж, нөхөрлөл, төрийн бус байгууллагуудад тарьц, суулгацын нөөц 7 дахин нэмэгдэж, 4 төрлийн шилмүүст модны 0.4 сая ширхэг, 20 төрлийн навчит модны 2.0 сая ширхэг тарьц, суулгацын нөөц бүрдүүллээ.<br><br>Мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа 21 иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын мод бут сөөгний тарьц, суулгацын нөөцийн үнийн судалгааг гаргаж олон нийтэд хүргэлээ. Мөн мод бут сөөгний үзэсгэлэн худалдааг Амарын талбайд 6 хоног зохион байгуулж ажилласан. Үзэсгэлэн худалдаанд оролцсон иргэд аж ахйун нэгж байгууллагууд нийт 6292 ширхэг модны тарьц суулгац худалдан борлуулж 94.4 сая төгрөгний борлуулалт хийсэн байна | 100% |
| 3.3 | Ногоон байгууламжийн арчилгаа хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах | 331.1 | Хамгаалалтын хашаажуулсан байршлын тоо | 3 | 4 | Хотын ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалтын ажилд 2 удаа үзлэг шалгалт зохион байгуулсан. ЦНБ газар нь нийт 320 м2 талбайг зүлэгжүүлэн, 3 байршилд /5,6-р микр, Хөх Монгол цогцолборт/ 1400 ш мод бутыг тарьж, Хотын хэмжээний 82300 у/м ургамлан хашлага тэгшлэх, хэлбэржүүлэх, усалгаа, бордолт хийж, 6200 ширхэг мод сөөгийг хортон шавьжаас сэргийлэн шохойлон, хор цацах, арчилгаа | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тордолтын ажлыг гүйцэтгэн ажилласан байна. Мөн хотын хэмжээнд цэцэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж 64000 ширхэг үрсэлгээ бэлдээд, тариалахад бэлэн болоод байна.<br><br>Малчид, тариалан эрхлэгчдийн зөвлөгөөнд оролцсон 100 гаруй иргэдэд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, Ногоон Эрдэнэт хөтөлбөрийг сурталчлан танилцуулж, мод тарих үйл ажиллагаанд хувийн хэвшил, иргэд, олон нийтийг оролцуулан мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мод тарилтын арчилгаа хамгаалалтыг сайжруулах талаар зөвөлгөөг хүргэлээ. Мөн байгаль хамгаалах арга хэмжээний зардлаар Хүрэнбулагийн аманд тарьсан моднуудын ургалтын хувийг нэмэгдүүлэх зорилгоор хамгаалалтын хашааг сэргээн засварлах, Баянцагаан багийн Вокзалын зам дагуух ногоон зурвасын хамгаалалтын хашааг сэргээн засварлах, Баян-овоот ууланд шинээр ойн төгөл байгуулан мод тарих нөхцлийг бүрдүүлэн хамгаалалтын хашааг шинээр барих зэрэг 3 байршилд ногоон байгууламжийн арчилгаа хамгаалалтыг сайжруулахаар ажлын даалгавар боловсруулан ажиллаж байна. | |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 6: ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ** | | | | | | | |
| **Зорилт-1. Гадаадын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 1.1 | Аймгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын | Орон нутгийн болон гадаадын | Удирдлагуудыг мэдээллээр хангаж ажиллах | Тухай бүрд мэдээллээр хангаж ажилласан. | Хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явц мэдээллээр хангаж | -ЕСБХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал" төслийн бүрэлдэхүүн Үерийн менежментийн хэсгийн худалдан авах ажиллагаа амжилттай зохион байгуулагдаж, шалгарсан компани | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийг тухай бүр гарган холбогдох газар хүргүүлэх, удирдлагуудыг мэдээллээр хангаи ажиллах | зээл, тусла мж | | | ажилласан байна. | Хунан Индастриал Икүпмент Инсталашн XXK-тай гэрээ байгууллаа. Гүйцэтгэгч компаниуд төслийн талбайд нүүж ирж, түр кемп байгуулан, бетон зуурмагийн үйлдвэрийг байгуулсан. Ажил эхлүүлэх зөвшөөрлийг тус бүр авчбарилгын ажлыг эхлүүлээд байна.Гүйцэтгэгч компаниудын урьдчилгаа төлбөрийн, гаалийн татвараас чөлөөлүүлэх болон дотоодоос худалдан авах бараа, материал, үйлчилгээний татвараас чөлөөлүүлэх хүсэлттэй холбоотой баримт баримт бичгүүдийг холбогдох журмын дагуу Сангийн яаманд хүргүүлэн шийдвэрлүүллээ. Төслийн үйл ажиллагааны, Байгаль орчин, нийгмийн, санхүүгийн болон бусад тайлангуудыг зөвлөхүүдтэй хамт боловсруулан Банк, СЯ-нд хүргүүлэв. Төслийн болон гүйцэтгэгч нартай холбоотой мэдээллийг СЯ-ны “Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн систем” /ODAMIS/-д шивж оруулсан. Төслийн ТУХ-ын хурлыг зохион байгуулж, ТХН-ийн 2024 оны үйл ажиллагааны аудитын дүгнэлт, гүйцэтгэгч компаниудын НӨАТ-аас чөлөөлүүлэх дотоодоос худалдан авах бараа, материал, үйлчилгээний жагсаалтыг батлуулах зэрэг асуудлыг хэлэлцүүлсэн. Төслийн хүрээнд Эрдэнэт Ус ОНӨХК-д хэрэгжүүлсэн Компанийн чадавхийг сайжруулах хөтөлбөрийн хугацааг сунгахтай холбоотой албан бичиг, гэрээний нэмэлт өөрчлөлт зэргийг боловсруулан холбогдох газруудад | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүргүүлсэн. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд хийгдсэн дотоод аудитын үнэлгээгээр нэгжийн ажилтнуудтай хийсэн хөлсөөр ажиллах гэрээг сунгахгүй шийдвэр гарсан. Үүний дагуу ТХН-ийн ажилтнуудын нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлан, ТХН-ийн шинэ бүтэц, орон тоог СЯ-аар батлуулсан.<br><br>Төслийн зээлийн санхүүжилт авах хугацаа дуусч байгааг сунгуулах албан бичгийг СЯ, ЕСБХБ-нд хүргүүлэн шийдвэрлүүлсэн. Төслийн барилгын ажил эхэлж байгаатай холбогдуулан төслийн нээлт, шав тавих ёслолыг төслийн зөвлөх, Банктай хамтран зохион байгуулсан.<br><br>- Польшийн хогны үйлдвэрийн төслийн хүрээнд хугацааг сунгасантай холбоотой төслийн ажлыг урагшлуулах төслийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг ирүүлэх талаар төслийн гүйцэтгэгч талд болон БНПУ-аас монгол улсад суугаа Элчин сайдад албан бичиг хүргүүлсэн. Төслийн ажил дуусаагүй тул санхүүжилтийг дараа жил болгон хойшлуулах тухай албан бичгийг Сангийн яаманд хүргүүлээд байна. Төслийн гүйцэтгэгч талд ажлаа хийхийг шаардсан албан бичиг дахин хүргүүлсэн. Төслийн гүйцэтгэгч талтай хамтран ажиллах ажлын хэсэг 4 удаа хуралдсан ба төслийн талбайд 2 удаа ажилласан. Төслийн ажлыг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үргэлжлүүлэн гүйцэтгэх, гүйцэтгэгч талыг төслийн талбайд ирж ажиллахыг шаардаж байгаа. | |
| 1.2 | НҮБ болон олон улсын байгууллагуудтай хөрөнгө оруулалтын чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтран ажиллах | Орон нутгийн болон гадаадын зээл, тусламж | Зохион байгуулалт хийсэн байдал | Тухай бүрд зохион байгуулж ажилласан. | Тухай бүрд зохион байгуулж ажилласан байна. | -НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монголын хүртээмжтэй ногоон хотууд” төслийн бичиг баримтыг боловсруулах үйл явцад бүхий л талаар дэмжлэг үзүүлж, салбар чиглэлийн мэргэжилтэн, холбогдох бичиг баримтыг цаг тухай бүрт илгээж, хэлэлцүүлэг уулкалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажилласан. Графикийн дагуу төслийн баг төслийн баримт бичгийг боловсруулан НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрт илгээсэн, одоогоор хариу хүлээсэн байдалтай байна.<br>-05-р сард зохион байгуулагдсан Хойд бүсийн Эдийн форумаар ЧИП багцыг олон нийтэд танилцуулах ажлыг зохион байгуулсан ба 2024 оны орон нутгийн төсөвт 130,000,000 төгрөгөөр аймгийн гэр хорооллын бүсэд оршин суудаг өрхүүдийг хамруулахаар төлөвлөсөн. Хамтран хэрэгжүүлэгч Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн Сангийн суурин төлөөлөгчийн газарт орон нутгийн оролцооны зардлыг шилжүүлэхээр зардлын захирамжийг оруулсан. Орон нутагт үйлдвэрлэгч нарыг бий болгох зорилгоор Улаанбаатар хотод сургалтад хамрагдаж, сертифиат авахад нь дэмжлэг үзүүлсэн.<br>-Баян-Өндөр сумын Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28-р цэцэрлэгийн байруудад нүүрстөрөгч бага | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ялгаруулдаг, цэвэр эрчим хүчний халаалтын системийг нэвтрүүлэх төсөл нь өнөөдрийн байдлаар 70 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд гэрээний хуваарийн дагуу 8 дугаар сарын 10-ны өдөр хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна.<br>-НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй жишиг ногоон сургуулийн барилгын зураг төсөв боловсруулах ажлын сонгон шалгаруулалт амжилт болсон. | |
| **Зорилт-2. Гадаад улс орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх** | | | | | | | |
| 2.1 | Гадны ЭСЯ болон хөтөлбөрийн газруудтай холбоотой ажиллаж, төслийн мэдээллээр аймаг орон нутгаа хангах | - | Гүйцэтгэлийн хувь | Хэрэгжилт 95 хувийн гүйцэтгэлтэй | Хэрэгжилт 90-ээс доошгүй хувийн гүйцэтгэлтэй байна. | Эхний хагас жилд Герман, АНУ, ОХУ, Чех улсууд болон Европын холбооны Элчин сайд, ЭСЯ-ны газар, хэлтсийн ажилтнууд Орхон аймагт ажилллав:<br>- Шинээр барьж ашиглалтад авсан Номын өргөөнд АНУ-ын ЭСЯ-тай хамтран "Америкийн соёл мэдээллийн төв"-ийг түшиглэн 2 удаа сургалт, мэдээллийн ажиллагаа зохион байгуулав.<br>-Чех улсын Элчин сайд болон Чехийн Аялал жуулчлалын Дэд сайдаар ахлуулсан төлөөлөгчид Орхон аймагт ажиллаж удирдлагуудтай уулзан санал солилцож, манай аймгийн хог хаягдлын менежменттэй танилцан цаашид хог шатаах том оврын зуух байгуулах асуудлаар санал тавьсан.Энэ төсөл нь Европын ЭКСИМ банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих боломжтой гэсэн мэдээлэл өгсөн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Япон улсын Токамачи хоттой сурагч солилцооны хөтөлбөрийг эхлүүлж, 6 сурагчийг шалгаруулсан бөгөөд тэд ирэх 9-р сараас Япон улсад очих юм.<br><br>-Тус улсын Засгийн газрын "Өвсний үндэс" хөтөлбөрийн газартай тогтмол мэдээлэл солилцож, өрсдийн хэрэгцээ шаардлагаа илэрхийлсэн 5 төслийг хүргүүлсэнээс БОЭТ-ийн төсөл эцсийн шатны хуралдаан орохоор шалгарсан.<br><br>-Монгол-Оросын найрамдал хамтын ажиллагааны өдрүүд, Эх орны дайны ялалтын өдөр зэрэг арга хэмжээнд 6,5 сая төг захирамжаар зарцуулж, Ерөнхий Консулын газар, Эрдэнэт үйлдвэртэй хамтран ажилласан.<br><br>-Япон, АНУ, Унгар, Герман улсын ЭСЯ-дад хандаж, виз авах шаардлагатай удирдах ажилтнуудын цаг, мэдүүлэг зэргийг бүрдүүлэн хүргүүлсэн байна.<br><br>- Европын холбооны Элчин сайд И.Марчёлюните хамтран хэрэгжүүлж байгаа "Гамшигт тэсвэртэй хот" төслийн хүрээнд үерийн даланг шинэчлэх ажлын нээлтийн ажиллагаанд оролцож аймгийн удирдлагуудтай уулзан санал солилцсон бөгөөд цаашид ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр хамтран ажиллах боломж байгааг цохон тэмдэглэв.<br>- ИКЛЭЙ Тогтвортой хөгжлийн төлөөх нутгийн захиргаадын олон улсын байгууллагын "Шинжлэх ухаанд суурилсан ногоон шилжилт 2025" олон улсын хотуудын захирагч нарын дээд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжээний уулзалтад оролцлоо. Монгол улсаас Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын төлөөллүүд оролцож, дэлхийн хотуудын тогтвортой хөгжлийн төлөө, байгальд түшиглэсэн, тойрог эдийн засгийг дэмжсэн, тэгш хүртээмжтэй хотыг бүтээж байгаа туршлагуудыг судаллаа. | |

*Төлөвлөгөөг үнэлсэн:* **Төсвийн Шууд захирагч**

АЗДТГ -ын дарга ........................ /Б.Ганзориг/

*(огноо)*

Тэмдэг 2025.06.12

*Төлөвлөгөөг тайлагнасан:* **Нэгжийн дарга**

ХБТХОХ-ийн дарга ........................ /С.Даваадорж/

*(огноо)*

2025.06.10